

**БАТЛАВ.**  
**УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮН.....**

**ҮНДСЭН ХУУЛИЙН ЦЭЦЭД МАРГААН ХЯНАН ШИЙДВЭРЛЭХ  
ТУХАЙ ХУУЛЬ /ШИНЭЧИЛСЭН НАЙРУУЛГА/-ИЙН  
ТӨСЛИЙН ҮЗЭЛ БАРИМТЛАЛ**

**Нэг. Хуулийн төсөл боловсруулах болсон үндэслэл, шаардлага**

Монгол Улс шинэ тогтолцоонд шилжиж анхны ардчилсан Үндсэн хуулиа 1992 онд батлахдаа Үндсэн хуулийн цэц /цаашид “Цэц” гэх/ нэртэйгээр Үндсэн хуулийн шүүхийг байгуулсан нь Үндсэн хуулийг чандлан сахиулах баталгаа болж, ардчилсан, эрх зүйт төртэй улсын түгээмэл чиг хандлагад нийцсэн алхам болсон. Цэц нь хууль, бусад шийдвэр Үндсэн хууль зөрчсөн эсэх маргааныг хянан шийдвэрлэж, зөрчсөн тохиолдолд тэдгээрийг хүчингүй болгох, тодорхой албан тушаалтныг огцруулах, эгүүлэн татах эрх мэдлийг буюу Үндсэн хуулийн хяналтыг хэрэгжүүлдэг.

Монгол Улсын Бага Хурлаас 1992 оны 5 дугаар сарын 8-ны өдөр Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн тухай хуулийг анх баталсан. УИХ-аас 1997 оны 5 дугаар сарын 1-ний өдөр уг хуульд тусгасан маргаан хянан шийдвэрлэхтэй холбоотой дийлэнх зохицуулалтыг хасаж, Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуульд зарчмын өөрчлөлт багатайгаар тусгаж, баталжээ. Эдгээр хууль тогтоомж нь Цэцэд маргаан хянан шийдвэрлэх эрх зүйн орчныг анх удаа бүрдүүлж, манай улсын Үндсэн хуулийн процессын эрх зүйн суурийг тавьсан.

Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуулийг анх 36 зүйлтэйгээр баталсан бөгөөд 2005, 2009, 2015, 2016, 2020, 2021 (энэ онд хоёр удаа), 2022 онд нийт 8 удаа нэмэлт, өөрчлөлт оруулаад байна. Хууль батлагдсанаас хойших хугацаанд зарим нэмэлт, өөрчлөлт орсныг эс тооцвол Үндсэн хуулийн үзэл баримтлал, суурь зарчим, нийгмийн хөгжлийн чиг хандлага, эрх зүйн шинэтгэлийн үйл явцтай уялдсан дорвитой өөрчлөлт хийгдээгүй. Энэ хууль нь эрүү, иргэн, захиргааны хэрэг хянан шийдвэрлэх хуулиудтай харьцуулахад маш товч, ерөнхий, ердийн шүүхэд хэвшсэн процессын шударга ёсны наад захын шаардлага тусаагүй хэмээн шүүмжилж ирсэн.

Хууль тогтоомжоор Цэцийн бүрэн эрхийг хэрэгжүүлэх арга замыг хэт явцууруулснаас болж, тодорхой тохиолдолд иргэний үндсэн эрх зөрчигдсөн тухай өргөдлийг хүлээн авч хянан шийдвэрлэх эрх зүйн орчин бүрдээгүй, Цэцийн харьяаллын ямар ч асуудлаар аливаа иргэн мэдээлэл гаргах, эрх бүхий байгууллага, албан тушаалтан хүсэлт гаргах боломжтой байгаа нь Цэцэд механик ачаалал бий болгох, Цэцэд хандах эрхээ урвуулан ашиглах эрсдэлийг нэмэгдүүлдэг гэж үздэг.

УИХ-ын 2020 оны 24 дүгээр тогтоолоор баталсан “Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр”-ийн 4.4.2 дахь заалтад “Цэцийн хараат бус, бие даасан, ил тод байдлыг хангаж, Цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны хууль, эрх зүйн орчныг боловсронгуй болгож Үндсэн хуульд ёс, хууль дээдлэх ёс, хүний эрхийг хангах тогтолцоог боловсронгуй болгоно” гэжээ. Түүнчлэн УИХ-ын 2021 оны 12 дугаар тогтоолоор баталсан

“Монгол Улсын хууль тогтоомжийг 2024 он хүртэл боловсронгуй болгох үндсэн чиглэл”-ийн 85-д Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай /шинэчилсэн найруулга/ хуулийн төслийг боловсруулж УИХ-д өргөн мэдүүлэх, энэ хүрээнд “Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хууль нь хэт ерөнхий, агуулгын хувьд Монгол Улсын Үндсэн хууль болон Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн тухай хуультай давхардсан зохицуулалт агуулсан, маргаан хянан шийдвэрлэх тухай хуулиар зайлшгүй зохицуулах зарим харилцааг зохицуулаагүйгээс Цэцийн дүгнэлт, шийдвэрт нөлөөлж байгааг өөрчлөх, Цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны дэгийг нарийвчлан зохицуулах”-аар заасан.

УИХ-ын 2003 оны 41 дүгээр тогтоолоор баталсан “Монгол Улсад хүний эрхийг хангах үндэсний хөтөлбөр”-ийн 1.1.1.2-т “Монгол Улсын хууль тогтоомжийг судалж, Үндсэн хуульд нийцүүлэх, хууль тогтоох үйл ажиллагаанд хүний эрхийн талаарх Үндсэн хуулийн үзэл баримтлалыг гуйвалтгүй мөрдлөг болгож, хүний эрхийг зөрчиж байгаа эсэхэд Үндсэн хуулийн цэц, бусад шүүхээс тавих хяналтыг хүч, нөлөөтэй болгоно,” 1.1.3.1.3-т “Үндсэн хуулийн цэцийн үйл ажиллагааг идэвхжүүлж, Үндсэн хуульд заасан хүний эрх зөрчсөн тохиолдлыг шийдвэрлэхэд онцгой үүрэгтэй ажиллуулах механизм бүрдүүлнэ,” 1.1.3.2.2-т “Хүний эрхийн Үндэсний Комисст Монгол Улсын Ерөнхийлөгч, Улсын Их Хурал болон Засгийн газрын гишүүд, Улсын дээд шүүхийн Ерөнхий шүүгч, Улсын ерөнхий прокурор Үндсэн хуульд заасан хүний эрх, эрх чөлөөний талаарх заалтыг зөрчсөн тухай асуудлаар иргэдээс гомдол гаргахад тэднийг төлөөлөн Үндсэн хуулийн цэцэд хүсэлт гаргаж шийдвэрлүүлэх эрх эдлүүлнэ” гэж тусгаад 20 жил болж буй ч эдгээд зорилт биелээгүй байна.

Цэцийг ардчилсан, эрх зүйт төртэй бусад улсын Үндсэн хуулийн шүүхийн нийтлэг жишигт ойртуулах, маргааныг Үндсэн хуулийнхаа үзэл баримтлалд нийцүүлэн онолын өндөр түвшинд, хараат бус, шударга, бодитой шийдвэрлэх эрх зүйн орчин, баталгааг бүрдүүлэх үүднээс Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх тухай хууль /шинэчилсэн найруулга/-ийг батлах шаардлага үүсээд байна. Хуулийн төслийг боловсруулахдаа Цэц үндсэн эрхийн маргааныг тухайн иргэний өргөдлөөр хянан шийдвэрлэх, Үндсэн хууль зөрчсөн тухай мэдээллийг аливаа иргэн бус, гагцхүү нийтийн ашиг сонирхлыг хамгаалах эрх бүхий этгээдээс иргэдийг төлөөлөн Цэцэд гаргах, маргаантай асуудлаар хүсэлт гаргахад хамаарлын зарчмыг баримтлах, түүнчлэн өргөдөл, мэдээлэл, хүсэлтэд тавих шалгуурыг нарийвчлан тусгах зэргээр Цэцэд маргаан хянан шийдвэрлэхтэй холбоотой харилцааг нарийвчлан зохицуулна.

### **Хоёр. Хуулийн төслийн ерөнхий бүтэц, зохицуулах харилцаа, хамрах хүрээ**

Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх тухай хуулийн төслийг Үндсэн хууль зөрчсөн тухай маргааныг Цэц иргэдийн өргөдөл, мэдээллийн дагуу өөрийн санаачилгаар буюу эрх бүхий байгууллага, албан тушаалтны хүсэлтээр хянан шийдвэрлэхтэй холбогдсон харилцааг зохицуулахаар боловсруулна.

Нэгдүгээр бүлэгт нийтлэг үндэслэл буюу хуулийн зорилт, хууль тогтоомж, нэр томъёоны тодорхойлолт, маргаан хянан шийдвэрлэх хүрээ, хугацаа, түүнийг тодорхойлох, тоолох, маргаан хянан шийдвэрлэхтэй холбогдон гарах зардлыг тооцох зохицуулалтыг тусгана.

Хоёрдугаар бүлэгт маргаан хянан шийдвэрлэх зарчим буюу хараат бус, хамтын, ил тод байх, тэгш эрхийг хангах, өөрөө нотлох, хуралдааныг биечлэн, тасралтгүй явуулах зарчим, маргаан хянан шийдвэрлэх хэл, бичгийн талаар тусгана.

Гуравдугаар бүлэгт Цэцэд хандах хэлбэр, хугацаа буюу өргөдөл, мэдээлэл, хүсэлтэд тавих шаардлага, тэдгээрийг хүлээн авах, бүртгэх журмыг тусгана.

Дөрөвдүгээр бүлэгт маргааны оролцогчийн эрх зүйн байдал буюу маргааны үндсэн болон бусад оролцогч, тэдгээрийн эрх, үүрэг, маргаан хянан шийдвэрлэх ажиллагаан дахь төлөөлөл, өмгөөлөгч, гэрч, шинжээч, орчуулагч, хэлмэрч, нарийн бичгийн даргын эрх зүйн байдлын талаар тусгана.

Тавдугаар бүлэгт маргаан хянан шийдвэрлэх нийтлэг журам буюу маргаан хянан шийдвэрлэх үндэслэл, өргөдөл, мэдээлэл, хүсэлт, маргааныг хуваарилах болон холбогдох бусад журам, маргаан хянан шийдвэрлэхэд бусад байгууллага дэмжлэг үзүүлэх, маргаан хянан шийдвэрлэх ажиллагааг түдгэлзүүлэх, маргааныг хэрэгсэхгүй болгох, ам хуралдааны тэмдэглэл хөтлөх талаар тусгана.

Зургадугаар бүлэгт маргаан хянан шийдвэрлэх зохион байгуулалт буюу хуралдааны хэлбэр, Бага, Дунд, Их суудал, тэдгээрийн хэлэлцэж шийдвэрлэх асуудлыг тодорхойлох, бэлтгэл хангах, ам хуралдаан явуулах, Цэцийн дүгнэлтийг УИХ-д хүргүүлэх болон маргааныг эцэслэн шийдвэрлэх зохицуулалтыг тусгана.

Долдугаар бүлэгт Цэцийн шийдвэр гаргах талаар буюу маргааныг зөвлөлдөх хурлаар хэлэлцэх, Цэцийн шийдвэрийн үндэслэлийг хэлэлцэн тогтоох журам, шийдвэрийн бүтэц, шийдвэрийг биелүүлэх, нийтлэх болон бусад журам, шийдвэрийн үр дагавар, Цэцээс хууль, бусад шийдвэрийг түр түдгэлзүүлэх зохицуулалтыг тусгана.

Наймдугаар бүлэгт тусгай журам буюу хууль, бусад шийдвэрт холбогдох маргаантай асуудал, Улсын дээд шүүх, Улсын ерөнхий прокурорын хүсэлтээр үүссэн маргаантай асуудал, албан тушаалтанд холбогдох маргаантай асуудал, үндсэн эрхийн маргаан, сонгох, сонгогдох үндсэн эрхийн маргаан, ард нийтийн санал асуулга, сонгуульд холбогдох маргаантай асуудлын талаарх тусгай зохицуулалтыг тусгана.

Есдүгээр бүлэгт бусад зүйл буюу хууль зөрчигчид хүлээлгэх хариуцлага, хууль хүчин төгөлдөр болох хугацааг заана.

**Гурав.Хуулийн төсөл батлагдсаны дараа үүсэж болох эдийн засаг, нийгэм, хууль зүйн үр дагавар**

Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуулийн төсөл батлагдсанаар дараах зарчмын шинэлэг зохицуулалт орж, холбогдох эрх зүй, эдийн засаг, нийгэм соёлын үр дагавар үүснэ гэж үзэж байна. Үүнд:

Ардчилсан, эрх зүйт төртэй бусад улсад Үндсэн хуулийн шүүхэд мэдээлэл гаргахыг иргэнд зөвшөөрдөггүй, харин зөвхөн үндсэн эрх зөрчигдсөн асуудлаар

л Үндсэн хуулийн шүүхэд өргөдөл гаргах эрхтэй байдаг. Гэтэл, Монгол Улсад Цэцийн тухай хууль тогтоомжоор Цэцийн харьяаллын аль ч маргаантай асуудлаар мэдээлэл гаргахыг иргэнд зөвшөөрсөн нь Цэцийн ачааллыг нэмэгдүүлдэг, улс төрийн болон бусад зүй бус нөлөөнд оруулах, хэт улс төржүүлэх эрсдэлтэй бөгөөд иргэний үндсэн эрх, эрх чөлөөг хамгаалж чаддаггүй. Иймд холбогдох төрийн бус байгууллага эсхүл Хүний эрхийн Үндэсний Комисс өөрт хандсан иргэдийг төлөөлөн Үндсэн хууль зөрчсөн асуудлаарх мэдээллийг Цэцэд гаргах боломж олгоно.

Цэц иргэдийн үндсэн эрхийн маргааныг шийдвэрлэхгүйгээс Монголд үндсэн эрх ноцтой зөрчигдөж, эдгээр зөрчлийг Үндсэн хуулийг хэрэглэж шийдвэрлэж чаддаггүй. Иймд, иргэн эрхээ хамгаалах хуульд заасан арга замыг дуусгасны дараа хууль тогтоох, гүйцэтгэх, шүүх эрх мэдлийн байгууллага, албан тушаалтны гаргасан шийдвэр, бусад акт өөрийнх нь үндсэн эрхийг зөрчсөн хэвээр байгаа гэж үзвэл Цэцэд өргөдөл гаргах, ингэснээр Цэц Үндсэн хуульд заасан үндсэн эрхийг тодорхой тохиолдолд хэрэглэж, “шууд үйлчилдэг эрх зүй” болгож, иргэний үндсэн эрхийн баталгаа болон хөгжинө.

Цэц Үндсэн хуулийн шүүх болохын хувьд хянан шийдвэрлэх маргааны агуулгыг “хамаарлын зарчмын” хүрээнд томьёолно. Ингэснээр хүсэлтэд тавих шаардлага, хүрээ хязгаарыг тогтоож, өөрийн үндсэн чиг үүрэгт үл хамаарах асуудлаар Цэцэд хандах боломжгүй болно. Энэ хүрээнд УИХ-ын гишүүдийн тавны нэгээс доошгүй нь маргаантай асуудлаар хүсэлт гаргах эрхтэй байхаар тусгаж, бусад улсын сайн туршлагын дагуу олонх, цөөнхийн тэнцвэрт байдлыг бий болгоно. Хууль тогтоогч нэгэнт олонхоор баталсан хуулиа олонх нь өөрөө Үндсэн хууль зөрчиж байгаа эсэхийг шийдвэрлүүлэхээр Цэцэд өгнө гэдэг бодитой биш. Мөн УИХ дахь олонх шаардлагатай гэж үзвэл Цэцэд хандахгүйгээр хууль тогтоомжийг өөрчлөх, хүчингүй болгох эрхтэй тул ийнхүү хандаж байгаагүй.

Цэцэд ирүүлэх өргөдөл, мэдээлэл, хүсэлтэд тавигдах шаардлага, хүлээн авахаас татгалзах үндэслэл, маргааныг хянан шийдвэрлэх үндэслэл, журмыг тодорхой болгож төсөлд тусгах бөгөөд Цэцийг Үндсэн хуулийн шүүхийн түвшинд хөгжүүлэх, түүний үйл ажиллагаа ил тод, нээлттэй байх, Цэцийн гишүүн хараат бус ажиллах, процессын шударга ёсыг хангана. Жишээлбэл, Цэцэд хандаж өргөдөл, мэдээлэл, хүсэлт гаргахад хугацааны хязгаарлалтыг тусгаагүй байсныг өөрчилж, бусад улсын сайн туршлага болон ердийн шүүхийн нийтлэг жишигт нийцүүлэн Цэцэд өргөдөл, мэдээлэл, хүсэлт гаргах хугацааг ялгамжтайгаар тодорхой зохицуулна. Энэ нь өргөдөл, мэдээлэл, хүсэлт гаргах эрх бүхий этгээд Цэцэд хандахдаа илүү хариуцлагатай хандах, Цэцийн хяналтын үр нөлөө дээшлэхээс гадна парламентаас баталсан хууль тогтоомжийг хүндэтгэх, түүний тогтвортой байдал, легитим шинжийг хангана.

Одоогийн хуулийн дагуу Цэцийн дарга өргөдөл, мэдээллийг Цэцийн гишүүнд хуваарилж, маргаан үүсгэх эсэх асуудлыг нэг гишүүн дангаар шийдвэрлэж, гомдол гаргасан тохиолдолд Цэцийн бага суудлын хуралдаанаар шийдвэрлэдэг. Үүнийг өөрчилж, төсөлд Цэц нь үндсэн эрхийн маргааныг хянан шийдвэрлэх, маргаан үүсгэх эсэх асуудлыг Цэцийн бага суудлын хуралдаанаар шийдвэрлэдэг байхаар шинэлэг зохицуулалт тусгана. Өргөдөл, мэдээллийг Бага суудалд хуваарилахаас өмнө урьдчилсан байдлаар Ерөнхий бүртгэлийн шүүлтүүр бий болгож, Цэцэд хандаж буй иргэнийг чирэгдүүлэхээс сэргийлэх, Цэцийн гишүүнийг шаардлагагүй ачааллаас хамгаалах боломжийг нэмэгдүүлнэ. Ерөнхий бүртгэгч нь Цэцэд ирсэн өргөдөл, мэдээлэл, хүсэлтийг хуульд заасан

хэлбэрийн шаардлагыг хангаагүй бол энэ тухай хариу өгөх чиг үүргийг хэрэгжүүлнэ.

Хүчин төгөлдөр мөрдөгдөж буй хуульд зааснаар өргөдөл, мэдээллийг урьдчилан шалгах хугацааг 14 хоног байхаар заасан бөгөөд хугацааг сунгах талаарх тодорхой зохицуулалт байхгүй, харин Цэцийн хуралдаанд бэлтгэх хугацаа 30 хоног байхаар заасан нь маргааныг бүрэн гүйцэт, бодитой, онолын түвшинд шийдвэрлэхэд оновчтой бус, хэт богино хугацаа юм. Иймд, Ерөнхий бүртгэгч нь өргөдөл, мэдээлэл, хүсэлтийг Цэцэд ирүүлснээс хойш 30 хоногийн дотор шаардлагыг хангасан эсэх зэргийг нягтлан үзэж, бүртгэх эсэхийг шийдвэрлэх, түүнчлэн бүтгэхээс татгалзсан хариуг маргагч тал эс зөвшөөрвөл 30 хоногийн дотор Цэцэд дахин хандаж болох, энэ тохиолдолд уул өргөдөл, мэдээлэл, хүсэлтийг ажлын таван өдрийн дотор Бага суудлын бүрэлдэхүүнд гардуулж бүртгэхээр зохицуулна. Цэц маргааныг үүсгэснээс хойш 90 хоногийн дотор хянан шийдвэрлэх бөгөөд тухайн маргаан ээдрээ, төвөгтэй бол энэ хугацааг 90 хоногоор хоёр хүртэл удаа сунгаж болохоор тусгаснаар бусад улсын жишигт нийцэхийн сацуу маргааныг мэдээлэл, судалгаа, тооцоололд үндэслэн тодорхой хугацааны дотор шийдвэрлэх ач холбогдолтой.

1997 оны Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуульд маргаан хянан шийдвэрлэх бүрэлдэхүүнийг томилох, өргөдөл, мэдээлэл, хүсэлтийг Цэцийн гишүүнд хуваарилах, бүрэлдэхүүнийг томилох асуудлыг Цэцийн дарга шийдвэрлэхээр хуульчилсныг олон улсын сайн туршлага болон Шүүхийн тухай хууль (2021) -д нэгэнт туссан дэвшилтэд зохицуулалтад нийцүүлэн өөрчилнө. Төсөлд өргөдөл, мэдээлэл, хүсэлтийг Бага суудалд хуваарилах, Бага, Дунд суудлын бүрэлдэхүүн, хуралдаан даргалагч, илтгэгч гишүүнийг томилох, маргааныг Дунд суудалд хуваарилах журамтай байх, уул журам нь урьдчилан мэдэх боломжгүй, санамсаргүй тохиолдлоор хуваарилах нөхцөлийг хангасан байх, шаардлага хангасан программ хангамжийг ашиглахаар заана. Ингэснээр эдгээр асуудлыг шийдвэрлэхэд үзэмжээр хандах боломжгүй болж, Цэцийн гишүүний хараат бус байдал, Цэцийн бие даасан, процессын шударга байдлыг нэмэгдүүлэх, Цэцийн гишүүдийн ажлын ачааллыг тэнцвэржүүлэх ач холбогдолтой.

Цэц дүгнэлтээ ёсчилсноос хойш 24 цагийн дотор УИХ-д хүргүүлэх, богино хугацаанд тогтоолоо бичиж эцэслэх шаардлага тавигддаг нь Цэцийн шийдвэрт үндэслэл дэлгэрэнгүй бичих боломжийг хязгаарладаг. Цэцийн шийдвэрийн үндэслэлийг онолын түвшинд, ойлгомжтой, үндэслэл сайтай гаргах шаардлагын үүднээс Цэцийн шийдвэр хүчинтэй болсноос хойш хоёр сарын дотор Цэцийн шийдвэрийг эцэслэн бичиж, ёсчлох, улмаар тодорхой хугацаанд нийтэд мэдээлэх, нийтлэх, эмхэтгэж хэвлэхээр хуульчилна.

Цэцийн гишүүн тусгай санал бичиж, хэвлүүлэх эрхтэй байхаар тусгана. Учир нь тусгай санал нь ямар нэг шууд үр дагаваргүй ч Үндсэн хуулийн шүүхийн практикийг шинжлэх ухааны үндэслэл бүхий, шийдвэр гаргах ажиллагааг ил тод, нээлттэй болгох, шүүгч шийдвэр гаргахдаа хараат бус ажилласан гэдгийг баталгаажуулах, Цэцийн гишүүний эрх тэгш, хараат бус байх баталгааг бүрдүүлэх ач холбогдолтой.

Цэц нь Үндсэн хуулийн шүүх болохын хувьд маргааны оролцогчдын эрх зүйн байдлыг тодорхой хуульчлах шаардлагатай байна. Энэ хүрээнд 1997 оны Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуулийн

дутмаг заалтыг өөрчилж, ердийн шүүхийн сайн туршлагад нийцүүлэн маргааны оролцогчдын эрх зүйн байдал, эрх, үүргийг нарийвчлан хуульчлах, өргөдөл, мэдээлэл, хүсэлт гаргагчийн шаардлагаасаа татгалзах, Цэцийн гишүүнийг татгалзан гарах зэрэг асуудлыг тусгайлан зохицуулна. Мөн Цэцийг үл хүндэтгэсэн, хуралдааны дэг болон хууль зөрчсөн этгээдэд хүлээлгэх хариуцлагыг тусгана.

Маргаан хянан шийдвэрлэхтэй холбоотой зохицуулалтыг нарийвчлан заах, түүнчлэн Цэцийн хяналтын онцлогтой уялдуулан Цэцийн хуралдааныг зөвлөлдөх хэлбэрээр буюу бичгээр зонхилон явуулах, онцгой тохиолдолд Цэцийн хуралдааныг ам хэлбэрээр явуулдаг болсноор онолын шүүх болох нөхцөл хангагдана гэж үзэж байна.

**Дөрөв. Хуулийн төсөл нь Монгол Улсын Үндсэн хууль болон бусад хуультай хэрхэн уялдах, түүнийг хэрэгжүүлэх зорилгоор цаашид шинээр боловсруулах буюу нэмэлт, өөрчлөлт оруулах, хүчингүй болгох хуулийн талаарх санал**

Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх тухай хууль /шинэчилсэн найруулга/-ийн төсөлтэй холбогдуулан бусад холбогдох хууль тогтоомжид нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг боловсруулна.

---oOo---